

2025 он 3 сар 20 өдөр

Дугаар 5/25

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 65 дугаар зүйлийн 65.1, 71 дүгээр зүйлийн 71.3, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Хувьцаа компанийн хурлын зар хүргэх журмын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /цаашид “Хурал” гэх/-ыг 2025 оны 4 сарын 29-ний өдрийн 11:00 цагт Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Централ Тауэрийн 17 давхарт, Криптос танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд мэдээлэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг Ард Апп (Ard App) болон цаасан хосолсон хэлбэрээр хэрэгжүүлэхээр зохион байгуулсугай.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2025 оны 4 сарын 7-ны өдрөөр тогтоосугай.
5. Хурлын даргаар Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн Б.Болорчимэгийг, дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр тус тус томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга
Г.Баярбат

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

Бизнес хөгжлийн албаны дарга С. Сайнбаяр
Санхүүгийн шинжээч Б. Номин
Хүний нөөцийн менежер Б. Ариунаа
Маркетингийн менежер Б. Сүнжидмаа
Мэдээлэл технологийн инженер Н.Бямбасүрэн
Дотоод аудитор П.Бямбасүрэн
Нярав Л.Насанбуян

6. Хурлын тооллогын комиссоор Ө.Бямбагэрэл, Ч.Даваацэрэн, А.Эрхбилгүүн нарыг сонгон ажиллуулсугай.
7. Хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар саналаа урьдчилан ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсонд тооцож, саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацааг 2025 оны 4 сарын 25-ны өдрийн 16 цаг 00 минут байхаар тогтоосугай.
8. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Хувьцаа компанийн хурлын зар хүргэх журмын дагуу Хурлын мэдэгдлийг Хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээлж, Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах боломж, нөхцөлөөр хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Г.Баярбат/-д даалгасугай.

ДАРГА



О. ОДБАЯР

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 3 сарын 20-ны
өдрийн 05/25 тоот тогтоолын Хавсралт №1

**2025 ОНЫ 4 САРЫН 29-НИЙ ӨДӨР ХУРАЛДАХ АРД ДААТГАЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт танилцуулах;
3. 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
4. 2025 оны ТУЗ-ийн төсөв танилцуулах;
5. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулж батлуулах;
6. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;
7. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай;

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 3 сарын 20-ны
өдрийн 05/25 тоот тогтоолын Хавсралт №2

**САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №1)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2025 оны 4 сарын 29-ний өдрийн 11 цаг 00 минутанд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Централ Тауэрийн 17 давхарт, Криптос танхимд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Саналын томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай			

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй бол компанийн байранд ирэх эсвэл www.arddaatgal.mn вэб сайтаас хурлын материалтай танилцаад энэхүү санал авах хуудсаар урьдчилан саналаа өгч болно.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2025 оны ... сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ (.....)

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 3 сарын 20-ны
өдрийн 05/25 тоот тогтоолын Хавсралт №2

**САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №2)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2025 оны 4 сарын 29-ний өдрийн 11 цаг 00 минутанд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Централ Тауэрийн 17 давхарт, Криптос танхимд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1.
2.
3.
4.
5.
6.
7.
№	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1.
2.
3.
4.
5.

Санамж:

1.Кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байна.

2.Кумулятив аргыг хэрэглэж, сонгогдсон ТУЗ-ийн нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

3.1.Хувьцаа эзэмшигч та ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.

Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____/...../

Санал авах хуудсыг үйлдсэн 2025 оны ...сарын ...-ны өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх:

Тооллогын комиссын дарга _____/...../

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 3 сарын 20-ны
өдрийн 05/25 тоот тогтоолын Хавсралт №2

**САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №1)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2025 оны 4 сарын 29-ний өдрийн 11 цаг 00 минутанд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Централ Тауэрийн 17 давхарт, Криптос танхимд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Саналын томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг батлах тухай			

4. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
5. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй бол компанийн байранд ирэх эсвэл www.arddaatgal.mn вэб сайтаас хурлын материалтай танилцаад энэхүү санал авах хуудсаар урьдчилан саналаа өгч болно.
6. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2025 оны ... сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ (.....)

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 3 сарын 20-ны
өдрийн 05/25 тоот тогтоолын Хавсралт №3

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 3 сарын 20-ны өдрийн 05/25 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай зарлаж байна.

Хурал хуралдуулах газар, өдөр, цаг: 2025 оны 4 сарын 29-ний өдрийн 11 цаг 00 минутанд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Централ Тауэрийн 17 давхарт, Криптос танхимд хуралд оролцох боломжтой бөгөөд мөн Ард Апп (Ard App) ашиглан хуралд саналаа өгөх боломжтой.

Компанийн оноосон нэр: Ард Даатгал ХК

Хурлын хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт танилцуулах;
3. 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
4. 2025 оны ТУЗ-ийн төсөв танилцуулах;
5. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулж батлуулах;
6. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;
7. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай;

Бүртгэлийн өдөр: 2025 оны 4 сарын 7-ны өдөр

Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудасны загвар;
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
4. 2024 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайлан;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.
6. Бусад шаардлагатай холбогдох баримтууд

Хувьцаа эзэмшигч та 2025 оны 3 сарын 24-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд ажлын цагаар өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандах, эсхүл www.arddaatgal.mn цахим хуудсаар зочлон хурлын материалтай танилцах боломжтой.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305-1307 тоот

Утас: 7720-0088 (Оператер)

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 3 сарын 20-ны
өдрийн 05/25 тоот тогтоолын Хавсралт №4

**АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ
ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ**

1. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудасны загвар;
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
4. 2024 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайлан;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл;
6. Бусад шаардлагатай холбогдох баримтууд;